



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/748

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Есөнзүйл сумын сум дундын эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд 2019 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Т.Гантулга (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Навчаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Дашжанцан (аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Стратеги, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал)

Н.Оюунтуяа (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга)

Д.Уранцэцэг (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны Төсөв, санхүү хариуцсан ажилтан)

П.Чимэг (Өвөрхангай аймаг дахь Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Гантулга) -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101630